



МОНГОЛ УЛС  
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/60

Чингис хот


Х.Ганчулуунд буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "г", Захиргааны ерөнхий хуулийн 40 дугаар зүйлийн 40.2.2, 40.2.4, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.20, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын Өлзийт тосгоны иргэн Хаянхярваагийн Ганчулуунд тохиолдсон ар гэрийн гачигдалд зориулан 300.000 /гурван зуун мянган/ төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжид шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ЦИДЭРБАТ

231010187